



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/81/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д. Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalai.d@audit.gov.mn](mailto:enkhdalai.d@audit.gov.mn)  
Аудитор: С.Отгонхорлоо  
Утас: 261740 Цахим хаяг: [otgonkhorloos@audit.gov.mn](mailto:otgonkhorloos@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК  
Захирал Н.Дэлгэрмаа  
Утас: 976-91910954 Цахим хаяг: [dabg.audit@yahoo.com](mailto:dabg.audit@yahoo.com)

Улаанбаатар хот  
2022 он

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	20
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	22
8. Аудитын илрүүлэлт .....	22
8.1 Залруулсан алдаа: .....	22
8.2 Төлбөрийн акт: .....	23
8.3 Албан шаардлага: .....	23
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХДК	Хадгаламж даатгалын корпораци



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/1576

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,547.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4, 20.2.6 заалтуудтай нийцээгүй, Тохиолдсон байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

1. ЗБДС-ийн удирдах зөвлөлийн 2020 оны 24-р тогтоолын дагуу 2,174.1 сая төгрөгийн 476 м2 оффисын барилгыг Чингис хаан банк ХХК-ийн авлагад тооцон худалдан авсан боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй, өөрийн өмчлөлд шилжүүлээгүй өмнөх оны зөрчил арилаагүй;
2. Өмнөх онд өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн 800.0 сая төгрөгийн зээлд 334.5 сая төгрөгийн батлан даалт гаргасан нь тухайн жилдээ чанаргүй зээл, 2021 онд муу зээлийн ангилалд бүртгэгдэж, зөрчил арилаагүй;
3. Зээлийн гэрээний дагуу холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй төслийн Худалдаа хөгжлийн банкны хадгаламжийн данснаас Төрийн банкин дахь харилцах дансанд 4,000.0 сая төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 1 дүгээр

сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд шилжүүлэн байршуулж, 38 7 сая төгрөгийн хүүгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

### **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

1. Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Ажлын байрыг дэмжих” зээлийг батлан даахад зориулж Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх” 12/02-02 дугаартай дөрвөн талт гэрээг байгуулсан байна. Гэрээний дагуу Хадгаламжийн даатгалын корпораци нь Зээлийн батлан даалтын сангийн үнэт цаасыг худалдан авч Сангийн яамны төрийн сангийн дансанд 50.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг байршуулсан. Зээлийн батлан даалтын сан нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гэрээний хавсралтын дагуу санхүүжилт авч Хадгаламжийн даатгалын корпорацид төлөхөөр тайлагнасан боловч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам авлагыг баталгаажуулаагүй байна.
2. Сангийн яамтай хийсэн 2016.12.16-ны 170/32 дамжуулан зээлдүүлэх гэрээний 3.2 "...ханшийн эрсдэлийг зээлдүүлэгч тал хариуцах бөгөөд зээлдэгч нь төлбөрийг зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр зээлдүүлэгчид төлнө..." заалтын дагуу Дамжуулан зээлийн санхүүжилтийн төгрөгөөрх үлдэгдлийг Сангийн яамнаас тайлант хугацааны эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд нийт 423 батлан даалтын хүсэлт хүлээн авч хэлэлцэн зээлийн эх үүсвэрээс 25, энгийн эх үүсвэрээс 5 батлан даалт тус тус гаргасан нь өмнөх оноос 71.5 хувиар буурсан байна.

Тайлант онд 12 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт орлого төлөвлөснөөс 4,174.8 сая төгрөг буюу 64.8 хувиар давсан нь хадгаламжийн хүүгийн орлого болон батлан даалтын шимтгэлийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал төлөвлөснөөс 2,317.4 сая төгрөг буюу 46.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь зээлийн хүү, амлалтын шимтгэлийг гүйцэтгэлээр зарцуулж 1,942.3 сая төгрөгийн дутуу зарцуулсан, Гүйцэтгэх захирлын 2021 оны А/09 дугаар тушаалын дагуу Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө баталж хэрэгжүүлснээр 375.1 сая төгрөгийн зардлын хэмнэлттэй ажилласан байна.

Хөрөнгө оруулалтаар нийт 10 ажилд 210.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, 93.2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	76,288,329,804.94	137,520,631,234.19
1.1.2	Бусад авлага	31,359,528,188.62	62,416,420,793.06
1.1.3	Бараа материал	33,256,911.27	41,772,022.27
1.1.4	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,584,144,392.98	2,517,288,590.47
1.1.5	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>110,265,259,297.81</b>	<b>202,496,112,639.99</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,379,925,935.63	2,450,840,315.71
1.2.2	Биет бус хөрөнгө	76,436,360.66	63,553,644.11
1.2.3	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	-	50,000,000,000.00
1.2.4	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,456,362,296.29</b>	<b>52,514,394,959.81</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>112,721,621,594.10</b>	<b>255,010,506,599.81</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,775,781,605.55	3,816,386,550.87
2.1.1.2	Урьдчилж орсон орлого	208,287,638.28	249,566,617.97
2.1.1.3	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,984,069,243.83</b>	<b>4,065,953,168.84</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	95,603,057,192.81	129,556,266,355.56
2.1.2.2	Бусад урт хугацаат өр төлбөр	240,000,000.00	50,080,000,000.00
2.1.2.3	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>95,843,057,192.81</b>	<b>179,636,266,355.56</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>97,827,126,436.64</b>	<b>183,703,219,524.40</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	8,000,000,000.00	58,000,000,000.00
2.3.2	Эздийн өмчийн бусад хэсэг	5,973,208,768.37	10,161,858,157.34
2.3.3	Хуримтлагдсан ашиг	921,286,389.09	3,146,428,918.07
2.3.4	Өмнөх үеийн үр дүн	723,398,744.34	(4,859,993,007.39)
2.3.5	Тайлант үеийн үр дүн	197,887,644.75	8,006,421,925.46
2.3.6	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>14,894,495,157.46</b>	<b>71,308,287,075.41</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>112,721,621,594.10</b>	<b>255,010,506,599.81</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>		
1.1	Хүүгийн орлого	7,682,634,332.19	9,756,903,369.08
1.2	Батлан даалтын хураамж, шимтгэлийн орлого	574,045,278.92	878,407,044.71
1.3	<b>Үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>	<b>8,256,679,611.11</b>	<b>10,635,310,413.79</b>
2	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>		
2.1	Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	2,589,651,585.59	1,057,710,161.16
2.2	<b>Ерөнхий удирдлагын зардал</b>	<b>1,470,540,626.27</b>	<b>1,571,177,550.45</b>
2.2.1	Цалин хөлс, шагнал	875,935,073.72	940,717,995.54
2.2.2	Нийгмийн даатгалын шимтгэл	56,156,732.72	113,890,170.41
2.2.3	Засвар үйлчилгээний зардал	24,253,256.50	29,597,020.00
2.2.4	Түрээсийн зардал	175,524,500.00	20,564,400.00
2.2.5	Албан томилолтын зардал	10,225,588.00	10,917,040.00
2.2.6	Элэгдлийн зардал	51,641,352.84	152,486,590.47
2.2.7	Зар сурталчилгааны зардал	32,157,270.00	83,990,129.72
2.2.8	Шуудан, холбооны зардал	7,807,862.87	8,585,080.05
2.2.9	Шатахууны зардал	22,107,846.73	18,619,650.32
2.2.10	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,835,992.00	33,182,610.00
2.2.11	Татварт төлсөн	96,855,834.89	116,109,574.42
2.2.12	Бусад зардал	37,039,316.00	42,517,289.52
2.3	<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>4,060,192,211.86</b>	<b>2,628,887,711.61</b>
2.4	<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал</b>	<b>4,196,487,399.25</b>	<b>8,006,422,702.18</b>
3	<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдлын дүн</b>	<b>5,756,083.24</b>	<b>(776.72)</b>
3.1	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	63,916.76	-
3.2	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	5,820,000.00	-
3.3	Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)	-	(776.72)
4	<b>Тайлант үеийн цэвэр үр дүн</b>	<b>4,202,243,482.49</b>	<b>8,006,421,925.46</b>



## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэн	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,800,000,000.00</b>	<b>2,911,807,884.23</b>	<b>723,398,744.34</b>	<b>11,435,206,628.57</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	167,276.56	<b>167,276.56</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>7,800,000,000.00</b>	<b>2,911,807,884.23</b>	<b>723,566,020.90</b>	<b>11,435,373,905.13</b>
Өмчид гарсан өөрчлөлт	200,000,000.00	3,804,523,114.30	(4,004,523,114.30)	-
Зарласан ногдол ашиг	-	(743,122,230.16)	-	<b>(743,122,230.16)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	4,202,243,482.49	<b>4,202,243,482.49</b>
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>8,000,000,000.00</b>	<b>5,973,208,768.37</b>	<b>921,286,389.09</b>	<b>14,894,495,157.46</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>8,000,000,000.00</b>	<b>5,973,208,768.37</b>	<b>921,286,389.09</b>	<b>14,894,495,157.46</b>
Өмчид гарсан өөрчлөлт	50,000,000,000.00	5,908,322,676.10	(5,781,279,396.48)	<b>50,127,043,279.62</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	(1,719,673,287.13)	8,006,421,925.46	<b>6,286,748,638.33</b>
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>58,000,000,000.00</b>	<b>10,161,858,157.34</b>	<b>3,146,428,918.07</b>	<b>71,308,287,075.41</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>818,363,017.20</b>	<b>32,317,198,636.25</b>
1.1.1	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	782,333,017.20	878,407,044.71
1.1.2	Бусад орлого	36,030,000.00	31,438,791,591.54
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,647,630,846.26</b>	<b>33,024,577,005.77</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	875,935,073.72	759,465,273.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	56,156,732.72	217,027,508.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,887,593.00	20,125,219.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	177,336,733.00	20,564,400.00
1.2.5	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	24,253,256.50	13,324,882.06
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	97,114,854.89	124,053,526.66
1.2.7	Бусад мөнгөн зарлага	404,946,602.43	31,870,016,196.10
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(829,267,829.06)</b>	<b>(707,378,369.52)</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>5,820,000.00</b>	<b>50,000,000,000.00</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	5,820,000.00	-
2.1.2	Хөрөнгө оруулалт	-	50,000,000,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>2,310,188,563.84</b>	<b>370,518,254.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,252,562,488.84	210,518,254.00
2.2.3	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,626,075.00	-
2.2.4	Хөрөнгө оруулалтын буцаалт	50,000,000.00	160,000,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,304,368,563.84)</b>	<b>49,629,481,746.00</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>19,073,662,095.79</b>	<b>14,029,870,563.18</b>
3.1.1	Зээлийн санхүүжилт	11,833,673,459.00	4,498,246,000.00
3.1.2	Хүү ба урамшууллын орлого	7,239,988,636.79	9,531,624,563.18
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>741,498,290.15</b>	<b>1,719,672,510.41</b>
3.2.1	Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)	-	(776.72)
3.2.2	Нөөц сангаас үүрэг гүйцэтгэсэн	741,498,290.15	1,719,673,287.13
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>18,332,163,805.64</b>	<b>12,310,198,052.77</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>15,198,527,412.74</b>	<b>61,232,301,429.25</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>61,089,802,392.20</b>	<b>76,288,329,804.94</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>76,288,329,804.94</b>	<b>137,520,631,234.19</b>

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>					
1.1	Үндсэн батлан даалт	389,691,000.00	890,000,000.00	738,000,000.00	152,000,000.00	82.9
1.2	Ажлын байрыг дэмжих 3% БД	-	-	28,456,424,392.00	(28,456,424,392.00)	
1.3	Банк бус санхүүгийн байгууллага	-	2,180,000,000.00	65,000,000.00	2,115,000,000.00	3.0
1.4	АХБ батлан даалт	12,253,717,459.00	27,630,000,000.00	4,498,246,000.00	23,131,754,000.00	16.3
1.5	<b>Нийт батлан даалт</b>	<b>12,643,408,459.00</b>	<b>30,700,000,000.00</b>	<b>33,757,670,392.00</b>	<b>(3,057,670,392.00)</b>	110.0
2	<b>Нийт орлого</b>	<b>8,256,679,611.11</b>	<b>6,440,262,213.92</b>	<b>10,635,310,413.79</b>	<b>(4,195,048,199.87)</b>	165.1
2.1	Үүнээс: /Батлан даалтын шимтгэл хураамж/	574,045,278.92	619,801,392.00	878,407,044.71	(258,605,652.71)	141.7
2.2	Хүүгийн орлого	7,682,634,332.19	5,820,460,821.92	9,756,903,369.08	(3,936,442,547.16)	167.6
3	<b>Нийт зардал:</b>	<b>4,060,192,211.86</b>	<b>4,962,475,204.75</b>	<b>2,628,888,488.33</b>	<b>2,333,586,716.42</b>	53.0
3.1	а) Үйл ажиллагааны зардал	1,470,540,626.27	1,962,475,204.75	1,571,177,550.45	391,297,654.30	80.1
3.2	б) Үйл ажиллагааны бус зардал /Хүү, АШ зардал/	2,589,651,585.59	3,000,000,000.00	1,057,710,937.88	1,942,289,062.12	35.3
4	<b>Цэвэр, ашиг алдагдал</b>	<b>4,196,487,399.25</b>	<b>1,477,787,009.17</b>	<b>8,006,421,925.46</b>	<b>(6,528,634,916.29)</b>	541.8
5	<b>Зарлагаас давсан орлогын нийт хуваарилалт</b>	<b>4,004,523,114.30</b>	<b>1,200,000,000.00</b>	<b>5,618,722,676.10</b>	<b>(4,418,722,676.10)</b>	468.2
5.1	Нөөцийн сан	3,566,729,491.64	1,000,000,000.00	5,000,000,000.00	(4,000,000,000.00)	500.0
5.2	Найдваргүй авлагын сан	237,793,622.66	200,000,000.00	618,722,676.10	(418,722,676.10)	309.4
5.3	Өөрийн хөрөнгө	200,000,000.00	-	-	-	
6	<b>Тайлант оны цэвэр ашиг</b>	<b>191,964,284.95</b>	<b>277,787,009.17</b>	<b>2,387,699,249.36</b>	<b>(2,109,912,240.19)</b>	859.5
7	б) Хөрөнгө оруулалт, их засвар	2,260,188,563.84	225,924,918.00	210,518,254.00	15,406,664.00	93.2

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 03 дугаар сарын 13-ны хооронд Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа, аудитор С.Цэнгэлмаа, Ө.Ундармаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг хэрэгжүүлсэн.

Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 90-ний өдрийн 1/61 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Удирдах зөвлөлийн дэргэдэх Хяналтын зөвлөлөөс хагас жил тутамд байгууллагын болон санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж зөвлөмж, шаардлага ирүүлдэг. Тайлант оны эхний хагас жилийн тайлантай танилцсан. Зээлийн батлан даалтын сангийн дотоод хяналтын мэргэжилтэн нь гүйцэтгэх захирлаар тайлант жилд 9 ажил төлөвлөн батлуулж, 11 ажил гүйцэтгэснээс төлөвлөгөөнд тусгагдаагүй 3 ажил гүйцэтгэж, аудитад 4 ажлын тайлан ирүүлсэн.

Дотоод хяналтын ажилтнаас оролцогч санхүүгийн байгууллагуудын батлан даалтын мэдээ, батлан даалтын хураамж шимтгэл, хадгаламжийн дансны хүүгийн тооцооллыг төсөл хэрэгжиж эхэлсэн 2017 оноос нарийвчилсан тооцооллуудыг хийн ирүүлснийг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

#### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 253,038.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,530.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Зээлийн батлан даалтын сангийн зорилго нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

Сан нь үйл ажиллагаандаа тэгш оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчилгүй, сайн засаглалын зарчмыг баримтална.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасны дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээс гаргасан хаалттай өрийн бичгээс банк, санхүүгийн байгууллага худалдаж авсан бол уг худалдаж авсан өрийн бичигт батлан даалт гаргах;
- Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах;

Сан нь үндсэн үйл ажиллагаатайгаа холбогдуулж дараах бусад үйл ажиллагааг явуулна:

- Зээлийн мэдээлэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллага, шаардлагатай бусад төрийн болон хувийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, лавлагаа авах;
- Зээлийн батлан даалт болон холбогдох бусад үйл ажиллагаанаас бий болсон хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулах зорилгоор тэдгээрийг бусдад худалдах, хуулиар зөвшөөрсөн бусад арга хэмжээг авах;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Сан статустай, дүрэмдээ ашгийн төлөө бус байгууллага байна гэж заажээ. Өмчийг 100.0 хувь төр эзэмшиж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Зээлийн батлан даалтын сангийн үүсгэн байгуулагчид нь Монгол Улсын Засгийн газар, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Ажил олгогчдын нэгдсэн холбоо байна. Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулагчдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит

хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай;

Сангийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Үүсгэн байгуулагчдын хурлаас томилж байгаа нь Зээлийн батлан даалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн хурлаар томилж байгаа нь тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 заалттай;

Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 56.2 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай тус тус нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд ТӨБЗГ-т Гүйцэтгэх захирлын 2021 оны 1/84 дүгээр албан бичгээр “сангийн үл хөдлөх хөрөнгө болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдан авах, данснаас хасах” асуудлыг шийдвэрлүүлэх талаар хариу авч, Удирдах зөвлөлийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор “Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7-д “Санд шинээр хөрөнгө бэлтгэх, хөрөнгийг шилжүүлэх, худалдан борлуулах, актлах асуудлыг Удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авч Төрийн өмчийн асуудал хариуцсан төв байгууллагаар шийдвэрлүүлнэ” гэсэн өөрчлөлт оруулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 заалтад нийцүүлэн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/09 дугаар тушаалаар “Хэмнэлтийн горимд шилжих арга хэмжээний төлөвлөгөө” батлан мөрдөж нийт төсвийг 19.1 хувиар хэмнэж ажилласан. Мөн орон тоо, зохион байгуулалтын бүтцийг Монгол улсын засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг хэрэгжүүлэхэд Сангийн Удирдах зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоолоор судалгаа хийж дүгнэлт гаргах, түүнд хяналт тавих, батлан даалтын хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх чиг үүрэг бүхий 5 мэргэжилтний орон тоог нэмж нийт орон тоог 43 болгон баталсан. Үүнтэй холбоотой тайлант онд нийт ажилчдын үндсэн цалинг нэмээгүй, үр дүнгийн урамшуулалт цалин олгоогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд 2021 оны 11 сарын 12-ны өдрийн өөрчлөлтөөр 1.1-д “Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 4.1-д “Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна”, 9.1.3-т “төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах”, 9.2-т “Сан нь энэ хуулийн 9.1-д заасан батлан даалтыг гаргахдаа тухайн зээл олгох банк, санхүүгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэнэ”;

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоол “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 42.3-д “Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн чадавхыг сайжруулж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан 50.0 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг зохих журмын дагуу гаргаж, Хадгаламжийн даатгалын корпорацид худалдах”, 42.4-т “өрийн хэрэгслийн үндсэн төлбөрт шаардагдах нэмэлт эх үүсвэрийг 10 жилийн хугацаагаар жил бүр тэнцүү хэмжээгээр улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлэх”;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх”

Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр Сангийн дараах дүрэм, журамд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд Удирдах зөвлөл 9 гишүүнтэй байх, Удирдах зөвлөлийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой байхаар зааж, уг хороодын үйл ажиллагааны чиглэлийг тусгаж;
- Батлан даалт гаргах журамд 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг Батлан даалтын газар судлах шийдвэрлэх эрхийг олгож, 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор Батлан даалт гаргах журмын шинэчилсэн найруулгыг баталж;
- 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журамд мөнгөн хөрөнгийг удирдах болон байршуулах нэр томъёог тодорхойлж, нөөц сан, найдваргүй авлагын сан байгуулах зохицуулалтад өөрчлөлт оруулсан;
- Зээлийн батлан даалтын хорооны үйл ажиллагааны журамд Удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг Батлан даалтын газар судлах шийдвэрлэх эрхийг олгож, 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 45 дугаар тогтоолоор зээлийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх зохицуулалтад өөрчлөлт оруулсан байна;
- 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 47 дугаар тогтоолоор Эх үүсвэртэй батлан даалтын журамд өөрчлөлт оруулж Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалтын нөхцөлд өөрчлөлт орсонтой холбогдуулан өөрчлөлтийг тусгажээ.

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Зээлийн батлан даалтын сангийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	76,288.4	137,520.6	61,232.2
Авлага	31,359.5	62,416.4	31,056.9
Урьдчилгаа	2,584.1	2,517.3	(66.8)

Бараа материал	33.3	41.8	8.5
Үндсэн хөрөнгө	2,379.9	2,450.8	70.9
Биет бус хөрөнгө	76.4	63.6	(12.8)
УХХО	-	50,000.0	50,000.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>112,721.6</b>	<b>255,010.5</b>	<b>142,288.9</b>
Өр төлбөрийн дүн	97,827.1	183,703.2	85,876.1
Богино хугацаат өглөг	1,984.1	4,065.9	2,081.8
Урт хугацаат өглөг	95,843.0	179,636.3	83,793.2
Эздийн өмч	14,894.5	71,308.3	56,413.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>112,721.6</b>	<b>255,010.5</b>	<b>142,288.9</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 2,115.4 сая төгрөг, хугацаатай хадгаламж 82,594.2 сая төгрөг, хугацаагүй хадгаламж 52,811.0 сая төгрөг байна.

### **Харилцах данс:**

Тайлант онд "Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.4-т "Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй" гэсний дагуу Хас, Капитрон, Чингис хаан банкуудад хүү хүлээн авах зориулалттай харилцах дансуудыг, төслийн санхүүжилтыг төгрөгөөр хүлээн авах зориулалттай Төрийн сан банкны харилцах дансыг хаасан байна.

Мөн дээрх хадгаламжийн хүү бодогдохгүй болсноос нөөц сангийн харилцах дансыг нээж үүрэг гүйцэтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна.

Сангийн үйл ажиллагааны 1 харилцах, төслийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэх зориулалттай 2 харилцах, маркетинг, зар сурталчилгаанд зориулсан ам.долларын 1 харилцах дансдад нийт 2,115.4 сая төгрөгийг тайлагнасан.

### **Хадгаламжийн данс:**

#### ***Хугацаатай хадгаламж:***

Хугацаатай хадгаламжийн дансыг өөрийн хөрөнгийн, Нөөц болон найдваргүй авлагын сангийн, аймаг дүүргүүдийн хөрөнгө оруулалтын, АХБ-ны зээлийн хүүгийн болон амлалтын шимтгэлийн, дундын дансны зориулалтаар ангилан нээж нийт 82,594.2 сая төгрөгийн хадгаламжийг байршуулсан.

Өөрийн хөрөнгийн хадгаламжийн данс 51,845.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наяд цогц төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд Хадгаламжийн даатгалын корпорациас 50,000.0 сая төгрөгийг Сангийн яамны төрийн сангийн хадгаламжийн дансанд хүлээн авч байршуулсан. Удирдах зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор батлан даалтын эх үүсвэрээс чөлөөлөгдсөн өөрийн хөрөнгө 1,845.3 сая төгрөгийг нэмж байршуулсантай холбоотой байна.

Нөөц сан ба найдваргүй авлагын сангийн хадгаламж 3,565.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь "Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.4.1-т зааснаар тайлант оны үр дүнгээс 62.7 хувь буюу 5,000.0 сая төгрөгөөр нөөц санг, 7.8 хувь буюу 618.7 сая төгрөгөөр найдваргүй авлагын санг нэмэгдүүлэн, 1,719.6 сая төгрөгөөр 7 аж ахуйн нэгжид үүрэг гүйцэтгэсэн дүнгээр буурснаас шалтгаалсан байна.

Аймаг дүүргүүдийн хөрөнгө оруулалтын хадгаламж 147.8 сая төгрөгөөр буурсан нь Хан-Уул дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв нь 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг буцаан татсантай холбоотой байна.



Төслийн зээлийн хүү, амлалтын шимтгэлд хуримтлуулсан хадгаламжийн данс 1,700.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ирээдүйд төлөх урт хугацаат зээлийн хүүгийн төлбөрт хуримтлуулах СЗХ-ны зөвлөмжийг үндэслэн тусгаарлан хадгаламж үүсгэсэнтэй холбоотой байна.

Дундын дансны хадгаламжийн дансанд тайлант хугацаанд эргэн төлөгдсөн батлан даалтын 11,611.7 сая төгрөгөөр нэмэгдэж, гаргасан батлан даалт 1,876.3 сая төгрөгөөр батлан даалтын эх үүсвэрийн хадгаламж руу шилжүүлж, 16,859.9 сая төгрөгийг тайлагнасан байна.

### **Хугацаагүй хадгаламж:**

Батлан даалтын эх үүсвэрийг АХБ-ны зээлийн гэрээний шаардлагын дагуу шалгарсан 6 банкинд байршуулж, тайлант оны гаргасан батлан даалт 4,498.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 11,122.1 сая төгрөгийн эргэн төлөлтөөр буурч, 52,811.0 сая төгрөгийг тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын батлан даалтын эх үүсвэрийг Капитрон банкинд 6,447.9 сая, Худалдаа хөгжлийн банкинд 21,480.7 сая, Хас банкинд 3,568.7 сая, Төрийн банкинд 18,792.4 сая, ХААН банкинд 1,621.1 сая, Голомт банкинд 900.3 сая төгрөгийг тус тус байршуулсан байна.

Бусад авлагын үлдэгдэлд төслийн санхүүжилтийн авлага 57,526.7 сая, хувь хүмүүсийн авлага 0.4 сая, батлан даалтын шимтгэлийн авлага 91.4 сая, үүрэг гүйцэтгэлийн авлага 3,351.5 сая, хадгаламжийн хүүгийн орлогын авлага 943.0 сая, бусад авлага 464.9 сая төгрөгийн авлага тус тус байна.

Тайлант онд нийт авлага 31,014.9 сая төгрөгөөр өссөн нь төслийн санхүүжилтийн авлага 28,464.1 сая, үүрэг гүйцэтгэлийн авлага 1,584.1 сая, хадгаламжийн хүүгийн орлогын авлага 500.4 сая, бусад авлага 466.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 60,758.8 сая, үүрэг гүйцэтгэлийн хугацаа хэтэрсэн 36.4 сая, найдваргүй авлага 1,582.6 сая төгрөгийн авлага тус тус байна. Төсөл хэрэгжүүлэх зээлийн эх үүсвэртэй батлан даалтын үүрэг гүйцэтгэлийг зээл төлөх чадваргүй болсноос хойш 90 хоног өнгөрсөн, үүрэг гүйцэтгэх эрсдэлийн санг байгуулсан, Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлийн ангилал зохих журмаар бүртгэгдсэн үед гүйцэтгэнэ. Энгийн эх үүсвэрийн батлан даалтын үүрэг гүйцэтгэлийг барьцаа хөрөнгийг зарж борлуулсны дараа шүүхийн шийдвэрээр үүрэг гүйцэтгэнэ. Тайлант онд 772.7 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, 1,010.5 сая төгрөгийг тайлагнасан, авлага хасаагүй болно.

Тайлант оны эцэст 2019 онд Азийн хөгжлийн банкны зээлийн хүү, амлалтын шимтгэл болон дамжуулан зээлийн хүүгийн төлбөрийг урьдчилан төлсөн тооцооны үлдэгдэл 2,514.5 сая төгрөг, сангийн үйл ажиллагаанаас үүссэн 1 жилээс дээш насжилттай 2.8 сая төгрөгийг тайлагнасан байна. Урьдчилгаа данснаас тайлант онд Сангийн яамны тооцоог үндэслэн 66.8 сая төгрөгийн дамжуулан зээлийн хүүгийн төлбөрийг төлж, зардалд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41.8 сая төгрөг болж 8.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авалтаар 26.2 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн хангамжийн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 210.5 сая төгрөгөөр өссөн нь Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2020 оны 34 дүгээр тогтоолоор баталсан 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу барилгын их засварт 185.6 сая, шинээр худалдан авсан үндсэн хөрөнгө 24.9 сая төгрөг, үүнээс тоног төхөөрөмж 20.3 сая, тавилга эд хогшил 4.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 2,174.1 сая төгрөгийн 476 м2 оффисын барилгыг Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2020 оны 24 дүгээр тогтоолын дагуу Чингис хаан банкны авлагад тооцон худалдан авсан боловч шүүх болон бусад хяналтын байгууллагуудаас эцэслэн шийдвэр гараагүй учир үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй,

өөрийн өмчлөлд шилжүүлээгүй нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгөнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Ажлын байрыг дэмжих” зээлийг батлан даахад зориулж Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх” 12/02-02 дугаартай дөрвөн талт гэрээг байгуулж, 50,000.0 сая төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалтыг бүртгэсэн байна.

Гэрээний дагуу Хадгаламжийн даатгалын корпораци нь Зээлийн батлан даалтын сангийн үнэт цаасыг худалдан авч Сангийн яамны төрийн сангийн дансанд 50,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг байршуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь ирэх 10 жилийн туршид өөрийн төсөвт тэнцүү дүнгээр санхүүжилтийг суулган Хадгаламж даатгалын корпорацид төлөхөөр тайлагнасан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд дансны өглөг 3,816.3 сая, урьдчилж орсон орлого 231.2 сая, нөөц өр төлбөрийн 0.1 сая төгрөгийн өр төлбөр байна.

Богино хугацаат өр төлбөр 2,063.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 7 байгууллагад үүрэг гүйцэтгэлийн 1,719.1 сая, батлан даалтын шимтгэлийн урьдчилж орсон орлого 231.2 сая, үйл ажиллагааны бусад өглөг 344.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд Сангийн яамтай 2016 онд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний урт хугацаат зээл 129,556.3 сая, аймаг дүүрэг, байгууллагуудаас хөрөнгө оруулсан 50,080.0 сая төгрөгийн өр төлбөрүүд байна.

Урт хугацаат зээлийн дансанд 2016 онд “Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлэх АХБ-наас санхүүжүүлж байгаа хөнгөлөлттэй зээлийг СЯ-тай дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулан зээлийн графикайн дагуу 49,369,945.00 ам.доллар буюу 126,034.9 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, нийт зээлийн хүүгийн зардал, амлалтын шимтгэлд төлөх 1,370,000.00 ам.доллар буюу 3,521.4 сая төгрөгийн өглөг үүсгэн хугацаандаа төлөгдөх 129,556.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн гэрээний хуваарийн дагуу 2028 оны 2 дугаар сараас эхлэн эргэн төлөлт хийгдэнэ.

Бусад урт хугацаат өр төлбөр дансны эхний үлдэгдэлд 2017 онд үүссэн Орхон аймгийн ЗДТГ-ын 50.0 сая, Архангай аймгийн ЗДТГ-ын 30.0 сая, 2016 онд үүссэн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын 160.0 сая төгрөгийн батлан даалтын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалтыг бүртгэж, тайлант онд Хан-Уул дүүрэг 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг буцаан татсанаар буурсан байна. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Арван их наядын цогц төлөвлөгөө”-ний “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн эх үүсвэрийг үнэт цаас гарган Хадгаламжийн даатгалын корпорацид худалдаж, санхүүжилтийг 2022 оноос 10 жилд тэнцүү дүнгээр хуваан төлөх нөхцөлөөр 50,000.0 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэсэн байна.

Эздийн өмчийн данс 56,373.9 сая төгрөгөөр өссөн. Үүнд:

- Өөрийн хөрөнгө тайлант онд Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын дагуу Арван их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 50,000.0 сая;
- Нөөц санг холбогдох журмын дагуу тайлант оны цэвэр үр дүнгээс 62.7 хувь буюу 5,000.0 сая төгрөгөөр байгуулж, өмнөх онуудын үүрэг гүйцэтгэлийн авлага барагдуулсан 135.6 сая төгрөгийг төвлөрүүлснээр нийт 5,135.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үүрэг гүйцэтгэсэн 1,719.7 сая төгрөгөөр буурч, нийт 3,415.6 сая;

- Найдваргүй авлагын нөөцийн санг тайлант оны цэвэр үр дүнгээс 9.7 хувиар буюу 618.7 сая, өмнөх аудитын зөвлөмжийн дагуу 2017-2019 онуудын нөөцийг нөхөн байгуулсан 154.0 сая, нийт 772.7 сая;
- Хуримтлагдсан үр дүнгийн данс 2,185.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг чиг үүргийн аргаар ангилж, орлого зардал зохицох зарчмаар хүлээн зөвшөөрч, аккрузл суурьт үндэслэн өртгөөр нь үнэлэн тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үндсэн үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Үндсэн үйл ажиллагааны зардалд төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний зардал, сангийн ерөнхий ба удирдлагын зардлыг хамруулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт ерөнхий ба удирдлагын зардлыг зардлын төрлөөр нь ангилан бүртгэнэ гэж заасан байна.

Өмнөх онтой харьцуулахад төсөл хөтөлбөрийн зардал 1,534.3 сая төгрөгөөр буурсан нь дамжуулан зээлдүүлэх гэрээний тайлант хугацаанд хамаарах хүү төлсөн, ерөнхий ба удирдлагын зардал 118.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох зардлууд болох цалин шимтгэл, элэгдлийн зардал нэмэгдэж, түрээс, шагнал урамшууллын зардал буурснаас шалтгаалжээ.

#### **4.4. Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Удирдах зөвлөлийн 2020 оны 33 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6,440.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,721.8 сая төгрөгөөр, зарлагаас давсан орлогын хуваарилалт 1,200.0 сая төгрөг, 518.5 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 225.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Удирдах зөвлөлийн 2021 оны 37 дугаар тушаалаар Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 240.7 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 10,635.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,628.8 сая төгрөгийн зардалтай, зарлагаас давсан орлогын 5,618.7 сая төгрөгийн хуваарилалт хийж, 2,387.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 10,635.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 4,195.0 сая төгрөг буюу 64.8 хувиар давсан нь хадгаламжийн хүүгийн орлого 3,936.4 сая, батлан даалт нэмэгдсэнтэй холбоотой шимтгэлийн орлого 258.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,628.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,333.6 сая төгрөг буюу 46.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь зээлийн хүү, амлалтын шимтгэлийг гүйцэтгэлээр зарцуулж 1,942.3 сая төгрөгийн дутуу зарцуулсан, Гүйцэтгэх захирлын 2021 оны А/09 дугаар тушаалын дагуу Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө баталж хэрэгжүүлснээр 391.3 сая төгрөгийн зардлын хэмнэлт гаргасан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 10 ажилд өөрийн эх үүсвэрээс 210.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,387.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,109.9 сая төгрөгөөр илүү байгаа нь хадгаламжийн хүүгийн болон батлан даалтын шимтгэлийн орлого нэмэгдсэн нь нөлөөлж байна.

Зээлийн батлан даалтын сан нь 2021 онд 12 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд нийт 423 батлан даалтын хүсэлт хүлээн авч хэлэлцэн зээлийн эх үүсвэрээс 9,343.1 сая төгрөгийн зээлд 4,495.8 сая төгрөгийн 25, энгийн эх үүсвэрээс 1,340.0 сая төгрөгийн зээлд 780.0 сая төгрөгийн 5 батлан даалт тус тус гаргасан байна.

Ковид-19 цар тахлын улмаас банкуудын зээл олголт багасч, батлан даалт гаргалт өмнөх онтой харьцуулахад зээлийн эх үүсвэрийн батлан даалт 60.0 хувиар буурч, энгийн эх үүсвэрийн зээлийн батлан даалт 33.0 хувиар өссөн.

Хүснэгт 2. 2020-2021 онд Гаргасан батлан даалтын харьцуулсан үзүүлэлт:

/сая.төгрөг/

Огноо	ЗБДХ-ны хурлаар хэлэлцсэн хүсэлтийн тоо	Батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн					
		АХБ			Үндсэн батлан даалт		
		Зээл	Батлан даалт	Тоо	Зээл	Батлан даалт	Тоо
2020 он	128	24,292.0	12,250.0	65	893.6	389.6	2
2021 он	423	9,343.1	4,495.8	25	1,340.0	738.0	5
Өссөн/ буурсан хувь	330.0	(60.0)	(72.0)	(60.0)	33.0	47.0	60.0

2021 оны жилийн эцсийн тайланд нийт батлан даалтын 13.2 хувь нь буюу 11,290.2 сая төгрөгийн чанаргүй, 1.6 хувь буюу 1,341.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн батлан даалтын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэртэй, 90 хоногоос дээш хугацаа хэтэрч, үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдсэн 22 иргэн, аж ахуйн нэгжийн 2,098.0 сая төгрөгийн батлан даалтын үлдэгдэл байна.

Шүүхэд хянагдаж байгаа 5 аж ахуйн нэгжийн 1,762.7 сая төгрөгийн батлан даалттай зээлийг барьцаа хөрөнгө борлуулж төлөлт хийсний дараах үлдэгдэлд үндэслэн, үүрэг гүйцэтгэнэ.

Хүснэгт 3. Батлан даалтын чанарын үзүүлэлт:

/сая.төгрөг/

Ангилал	Зээлийн үлдэгдэл	Батлан даалтын үлдэгдэл	Зээлдэгчийн тоо	Багцад эзлэх хувь
<b>Нийт дүн</b>	167,135.7	85,384.3	590	100.0
Хэвийн	140,090.5	72,752.8	496	85.2
Хугацаа хэтэрсэн	2,758.7	1,341.2	10	1.6
<b>Чанаргүй</b>	<b>24,286.5</b>	<b>11,290.2</b>	<b>84</b>	<b>13.2</b>
-Хэвийн бус	2,385.4	1,057.6	7	1.2
-Эргэлзээтэй	4,427.3	2,356.2	11	2.8
-Муу	17,473.7	7,876.3	66	9.2

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 385 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журамд заасан 12 шалгуур үзүүлэлтийг тайлант онд хамаарах 10 үзүүлэлтийг дараах байдлаар хангасан байна.

Хүснэгт 4. Санхүүгийн зохицуулах хорооны шалгуур үзүүлэлт:

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
-----	-------------------	--------------	------------	---------------

<b>А. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>					
1	Өөрийн хөрөнгийн байвал зохих доод хэмжээ /төгрөгөөр/	5,000,000,000.00	71,271,831,276.92	-	Хангасан
2	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	27.9%	-	Хангасан
3	Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	85,384,330,325.20	-	Хангасан
<b>Б. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>					
4	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	106.0%	-	Хангасан
<b>В. АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>					
5	Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60.0%	-	Хангасан
6	Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	3.5%	-	Хангасан
7	Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.0%	-	-
8	Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.0%	-	-
<b>Г. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА</b>					
9	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	2.2%	-	Хангасан
<b>Д. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>					
10	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.2%	-	Хангасан
<b>Е. НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>					
11	Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт /тайлант жилийн цэвэр үр дүнгийн 50%-аас дээш/	3,982,985,470.94	10,161,858,157.34	-	Хангасан
<b>ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА</b>					
12	Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	13.2%	-	Хангасан

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Зээлийн батлан даалтын сан нь тайлант онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын зөвлөмжийн мөрөөр авч

хэрэгжүүлсэн арга хэмжээний 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 31.6 сая төгрөгийн төсөвтэй, 8 нэр төрлийн 18 ш тоног төхөөрөмж авахаар баталснаас нэр төрөл өөр 20.3 сая төгрөгийн 5 нэр төрлийн 6 ш тоног төхөөрөмж авсан байна. Засварын ажлын 185.6 сая төгрөгийн худалдан авалтын тендерийн материалыг аудитын явцад танилцуулаагүй, худалдан авалтын цахим систем tender.gov.mn-д тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журмын 3.12 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 3.13-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан төлөвлөгөөнд тусган, цахим системд бүртгэж, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулахаар цахим системээр илгээнэ" заалтад нийцээгүй, худалдан авах ажиллагааны хуулийг хэрэгжүүлээгүй тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 136,574.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснийг залруулсан байна. Үүнд:

- 2021 оны 1-9 дүгээр сарын батлагдсан цалингийн хүснэгтээрх тооцооллыг 7.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Оролцогч санхүүгийн байгууллагуудын тайлантай тулгасан батлан даалтын мэдээ тайлан ирүүлээгүй, батлан даалтын шимтгэлийг аккруэл сууриар бүртгээгүй 830.2 сая төгрөгөөр зөрүүтэй;
- НЭС программаас 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх "Зээлийн батлан даалтын хөдөлгөөний тайлан", "Эх үүсвэрийн дансны үлдэгдлийн дэлгэрэнгүй" тайланг татан авч СЗХ-нд өгсөн тайлантай тулгахад батлан даалтын хөдөлгөөний тайланд 76 харилцагчийн 5,882.1 сая төгрөгийн үлдэгдэл зөрүүтэй;
- Дамжуулан зээлийн санхүүжилт, зээлийн хүүгийн тооцооллыг өмнөх оны эцэст болон завсрын аудитаар 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх 129,800.9 сая төгрөгийг СЯ-нд тооцоо нийлэхээр хүргүүлсэн боловч баталгаажуулаагүй;
- Голомт, Капитрон, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудын хадгаламжийн гэрээний дагуу тооцоолсон хүүгийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүй 53.7 сая төгрөгөөр зөрүүтэй;

Дамжуулан зээлдүүлэх гэрээний үлдэгдлийн тооцоог СЯ-нд ам.доллар болон төгрөгөөр хийж тайлангийн эцэст хүргүүлж байгаа боловч тооцоог баталгаажуулаагүй. 2021 оны жилийн эцсийн үлдэгдэлд аудитын тулган баталгаажуулах захидал илгээж хариуцсан мэргэжилтэн баталгаажуулан гарын үсэг зурж ирүүлсэн тул залруулснаар тооцсон.

Завсрын аудитаар шилэн дансны болон худалдан авах ажиллагааны хуулийг хэрэгжүүлээгүй, 20.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа тул нийцлийн аудитын 5.2 хэсэгт дүгнэлтийг орууллаа.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,763.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 1,529.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс төлбөрийн акт, зөвлөмж 100.0 хувь, албан шаардлага 40.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 5.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	2.9	1	2.9	-	-	100.0
Албан шаардлага	5	3,763.9	2	1,255.3	3	2,508.6	40.0
Зөвлөмж	2	1,529.6	2	1,529.6	-	-	100.0
Нийт дүн	8	5,296.4	5	2,787.8	3	2,508.6	62.5

Чингис хаан банкны авлагыг барагдуулж худалдан авах гэрээ хийсэн 2,174.1 сая төгрөгийн өртөгтэй оффисын барилгыг өөрийн өмчлөлд шилжүүлээгүй, өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 334.5 сая төгрөгийн батлан даалтыг олгохоор шийдвэр гаргасан зөрчилд хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Хэрэгжүүлээгүй 2 асуудлыг жилийн эцсийн аудитын илрүүлэлтэд шилжүүлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны эцэст чанаргүй болон хугацаа хэтэрсэн 12,631.5 сая төгрөгийн батлан даалтын үлдэгдэл тайлагнасан нь СЗХ-ны тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа үзүүлэлттэй байна.

Үүнээс Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэртэй, 90 хоногоос дээш хугацаа хэтэрч, үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдсэн 22 иргэн, аж ахуйн нэгжийн 2,098.0 сая төгрөгийн батлан даалтын үлдэгдэл байна. Шүүхэд хянагдаж байгаа 5 аж ахуйн нэгжийн 1,762.7 сая төгрөгийн батлан даалтад үүрэг гүйцэтгэх болсон байна.

Үүрэг гүйцэтгэлийн гэрээний нөхцөл, гэрээний хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзнэ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52,563.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 50,016.2 сая төгрөгийн алдааг залруулж, 38.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,508.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй 2,547.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2,530.4 мянган төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс 16.9 мянган төгрөгөөс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 50,016.2 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Арван их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд Ажлын байрыг дэмжих зээлийн эх үүсвэрийг ХХААХҮЯ-ны төсөвт 10 жилийн хугацаанд суулган санхүүжүүлэх урт хугацаат хөрөнгө оруулалт 50,000.0 сая төгрөгийг богино хугацаат авлагаар тайлагнасан.
- Биет бус хөрөнгийн элэгдлийн зардлыг 16.2 сая төгрөгөөр илүү тооцож тайлагнасан.

**8.2 Төлбөрийн акт:**

Худалдаа хөгжлийн банкны хадгаламжийн данснаас Төрийн банкин дахь харилцах дансанд 4,000.0 сая төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зээлийн гэрээний дагуу холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй шилжүүлэн байршуулж, 38.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах"; Зээлийн гэрээний 4.01.н, Төсөл хэрэгжүүлэх зааврын В.42 "...Хугацаат хадгаламж, эскроу данснаас олсон хүүгийн орлого ЗБДС-гийн үйл ажиллагааны харилцах данс руу шилжинэ..." гэсэн заалттай нийцээгүй, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн орлогыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоох

**8.3 Албан шаардлага:**

1. ЗБДС-ийн удирдах зөвлөлийн 2020 оны 24-р тогтоолын дагуу 2,174.1 сая төгрөгийн 476 м2 оффисын барилгыг Чингис хаан банк ХХК-ний авлагад тооцон худалдан авсан боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй, өөрийн өмчлөлд шилжүүлээгүй зөрчилд өмнөх аудитаар албан шаардлага хүргүүлсэн. Тайлант оны эцэст дээрх үл хөдлөх хөрөнгө нь өөрийн өмчлөлд шилжин ирээгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, зөрчил арилаагүй байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 6.2 "төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", НББТХ-ийн 13.4 "Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил арилаагүй тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх онд өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн 800.0 сая төгрөгийн зээлд 334.5 сая төгрөгийн батлан даалт гаргасан нь тухайн жилдээ чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдэж, 2021 онд муу зээлийн ангилалд орсон, зөрчил арилаагүй байна.

Энэ нь ЗБДС-ийн УЗ-ийн 2020 оны 22-р тогтоолоор баталсан Батлан даалт гаргах журмын 3.2-т "батлан даалтын судалгаа, үнэлгээг батлан даалт гаргах эсэх, батлан даалтын нөхцөлийг өөрчлөх зорилгоор хийнэ" гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил арилаагүй тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	ЗБДС	АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	Арван их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд Ажлын байрыг дэмжих зээлийн эх үүсвэрийг ХХААХҮЯ-ны төсөвт 10 жилийн хугацаанд суулган санхүүжүүлэх урт хугацаат хөрөнгө оруулалт 50,000.0 сая төгрөгийг богино хугацаат авлагаар тайлагнасан	СБД-ын тайланд бусад хөрөнгөөр залруулан тайлагнах	1	50,000,000.0	1	50,000,000.0								
2	ЗБДС	АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	Биет бус хөрөнгийн элэгдлийн зардлыг 16.2 сая төгрөгөөр илүү тооцож тайлагнасан	Орлогын дэлгэрэнгүй тайланд элэгдлийн зардлыг залруулан тайлагнах	1	16,203.7	1	16,203.7								
3	ЗБДС	АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	Худалдаа хөгжлийн банкны хадгаламжийн данснаас Төрийн банкинд дахь харилцах дансанд 4,000.0 сая төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зээлийн гэрээний дагуу холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй шилжүүлэн байршуулж, 38.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн	Дутуу төвлөрүүлсэн орлогыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоох	1	38,663.0			1	38,663.0						
4	ЗБДС	АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	ЗБДС-ийн удирдах зөвлөлийн 2020 оны 24-р тогтоолын дагуу 2,174.1 сая төгрөгийн 476 м2 оффисын барилгыг Чингисхаан банкны авлагад тооцон худалдан авсан боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй, өөрийн өмчлөлд шилжүүлээгүй зөрчилд өмнөх аудитаар албан шаардлага хүргүүлсэн. Тайлант оны эцэст дээрх үл хөдлөх хөрөнгө нь өөрийн өмчлөлд шилжин ирээгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, зөрчил арилаагүй байна	Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил арилаагүй тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.	1	2,174,060.5						1	2,174,060.5			
5	ЗБДС	АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	Өмнөх онд өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн 800,000.0 мянган төгрөгийн зээлд батлан даалт гаргасан нь тухайн жилдээ чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдэж, 2021 онд муу зээлийн ангилалд орсон, зөрчил арилаагүй байна	Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил арилаагүй тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх	1	334,447.0						1	334,447.0			
<b>ДҮН</b>					5	52,563,374.2	2	50,016,203.7	1	38,663.0	-	-	2	2,508,507.5	-	-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	ЗБДС		Зээлийн батлан даалтын сан нь тайлант онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг	1	-						1	-			

Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна	давтан гаргасан тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх												
2	ЗБДС	АХГ-2022/81/НА-СТА-ТӨА	Тайлант онд батлагдсан ХАА-ны төлөвлөгөөнд 31,569.5 мянган төгрөгийн төсөвтэй, 8 нэр төрлийн 18 ш тоног төхөөрөмж авахаар батлагдсанаас нэр төрөл өөр 20,257.6 мянган төгрөгийн 5 нэр төрлийн 6 ш тоног төхөөрөмж авсан байна. Засварын ажлын 185,596.9 мянган төгрөгийн худалдан авалтын тендерийн материалыг аудитын явцад танилцуулаагүй, худалдан авалтын цахим систем tender.gov.mn-д тайлагнаагүй байна	СС-ын 2021оны 102 дугаар тушаалаар баталсан ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журмын 3.12 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 3.13-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан төлөвлөгөөнд тусган, цахим системд бүртгэж, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулахаар цахим системээр илгээнэ" заалтад нийцээгүй, худалдан авах ажиллагааны хуулийг хэрэгжүүлээгүй тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	205,854.5					1	205,854.5				
<b>ДҮН</b>					2	205,854.5	-	-	-	-	1	205,854.5	1	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>					7	52,769,228.7	2	50,016,203.7	1	38,663.0	2	205,854.5	3	2,508,507.5	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 93/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/81/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдаа хөгжлийн банкны хадгаламжийн данснаас Төрийн банкна дахь харилцах дансанд 4,000,000,000.00 төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд АХБ-ны зээлийн гэрээний дагуу холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй шилжүүлэн байршуулж, 38,663,013.70 төгрөгийн хүүгийн орлогог дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах"; Зээлийн гэрээний 4.01.h Төсөл хэрэгжүүлэх зааврын В.42 "...Хугацаат хадгаламж, эскроу данснаас олсон хүүгийн орлого ЗБДС-гийн үйл ажиллагааны харилцах данс руу шилжинэ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутуу төвлөрүүлсэн хүүгийн орлого 38,663,013.70 /Гучин найман сая зургаан зуун жаран гурван мянга арван дөрвөн/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Уранбилэг нардаар даалгав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:

Ш. Алтанчимэг

Б. Уранбилэг

Ш.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА

9006109  
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-212310

10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0315 Auditin 2 Gazar-90.Docx

001090247



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 430/А0150053  
АХГ-2022/М/НА-СТА-ТӨА.

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зээлийн батлан даалтын сан нь тайлант онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "энэ хуулийн 42.1, 42.1-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Зөрчлийг давтан гаргасан Зээлийн батлан даалтын сангийн ерөнхий нягтлан бодогч Б.Уранбилэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанчимэгт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Н.ДЭЛГЭРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 431/АМ50053  
АХГ-2022/М/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 31,569,500.00 төгрөгийн төсөвт өртөгтэй 8 нэр төрлийн 18 ш тоног төхөөрөмж авахаар тусгаснаас нэр төрөл өөр 20,257,600.00 төгрөгийн 5 нэр төрлийн 6 ш тоног төхөөрөмж авсан байна. Басварын ажлын 185,596,955.00 төгрөгийн худалдан авалтын тендерийн материалыг аудитын явцад танилцуулаагүй, худалдан авалтын цахим систем tender.gov.mn-д тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 49 дүгээр зүйлийн 49.1 "Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална", 49.3 "Энэ хуулийн 49.1 заасан баримт бичиг, материалтай төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хууль, хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтан танилцах эрхтэй", Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг мөрдөх журам"-ын 3.12 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 3.13 заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан төлөвлөгөөнд тусган цахим системд бүртгэж, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулахаар цахим системээр илгээнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь нэмэлт, өөрчлөлтийг хянаж, цахим системээр батална", 4.1 "Захиалагч нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим системийн холбогдох талбарт энэ журмын хавсралтын маягт 2-ын дагуу боловсруулж, энэ журмын 2 дугаар зүйлд заасан үе шатны дагуу холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор цахим системээр ирүүлнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан дүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө",

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авалтыг төлөвлөх, тайлагнах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Уранбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 432/АД150053  
АХГ-2022/М/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зээлийн батлан даалтын сангийн удирдах зөвлөлийн 2020 оны 24 дүгээр тогтоолын дагуу 2,174,060,548.84 төгрөгийн өртөг бүхий 476 м2 оффисын барилгыг Чингис хаан банк УХК-ны авлагад тооцон худалдан авсан боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ аваагүй, өөрийн өмчлөлд шилжүүлээгүй зөрчилд өмнөх аудитаар албан шаардлага хүргүүлсэн. Тайлант оны эцэст дээрх үл хөдлөх хөрөнгө нь өөрийн өмчлөлд шилжүүлээгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гаргаагүй, зөрчил арилаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 "төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адал хамаарна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн асуудалтай холбоотой өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зээлийн батлан даалтын сангийн удирдах зөвлөлийн дарга Г.Пүрэвсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХӨӨРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ ВИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 433/АОА50053

Улаанбаатар хот

АХГ-2022/81/НА-СТА-Т6А

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Зээлийн батлан даалтын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн 800,000,000.00 төгрөгийн зээлд гаргасан батлан даалтын үлдэгдэл 334,447,073.00 төгрөгийн үлдэгдэл нь 2020 оны эцэст эргэлзээтэй зээлийн ангилалд бүртгэгдэж, 2021 онд муу зээлийн ангилалд орсон, зөрчил арилаагүй байна.

Энэ нь Зээлийн батлан даалтын сангийн удирдах зөвлөлийн 2020 оны 22 дугаар тогтоолоор баталсан Батлан даалт гаргах журмын 3.2-т "батлан даалтын судалгаа, үнэлгээг батлан даалт гаргах эсэх, батлан даалтын нөхцөлийг өөрчлөх зорилгоор хийнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Чанаргүй батлан даалт гаргасан асуудлаар өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан буруутай албан тушаалтнуудад хуульд зааснаар сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанчимэгт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Н.ДЭЛГЭРМАА



